

## **Монгол Улс ба НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл**

Хүний эрхийн зөвлөл (ХЭЗ) нь дэлхий дахинаа хүний эрхийг дээдлэх, хамгаалах, хүний эрхийг хангах асуудлыг хэлэлцэж, энэ зорилтоо хэрэгжүүлэхэд чиглэсэн шийдвэр, зөвлөмж баталдаг. Тухайлбал, 1) Дэлхийн бүх улсыг хамарсан Хүний эрхийн төлөв байдлын ээлжит хэлэлцүүлэг (Universal Periodic Review-UPR)-ийн хүрээнд НҮБ-ын гишүүн улс бүрийн хүний эрхийн байдлыг хянан хэлэлцэж, үнэлгээ өгөхийн зэрэгцээ, цаашид анхаарах асуудлаар зөвлөмж өгөх, 2) хүний эрхийн зөрчлийг олон улсын хамтын нийгэмлэгийн анхааралд хүргэж, түүнийг шийдвэрлэх арга хэмжээ авах, 3) хүний эрхийг хамгаалах гэрээ, конвенциор хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх талаарх гишүүн орнуудын чадавхийг бэхжүүлэх, техникийн туслалцаа үзүүлэх, 4) хүний эрхийн асуудлаарх олон улсын эрх зүйг боловсронгуй болгох чиглэлээр НҮБ-ын Ерөнхий Ассамблейд зөвлөмж танилцуулах зэрэг үйл ажиллагаа явуулдаг. ХЭЗ ажлаа Ерөнхий Ассамблейд тайлагнадаг.

НҮБ-ын Ерөнхий Ассамблей 2006 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн 60/251 дүгээр тогтоолоороо НҮБ-ын гишүүн 47 улсын бүрэлдэхүүнтэй Хүний эрхийн зөвлөл (ХЭЗ) байгуулахаар шийдвэрлэсэн. ХЭЗ нь жил бүрийн 3 дугаар сар (4 долоо хоног), 6 дугаар сар (3 долоо хоног), мөн 9 дүгээр сард (3 долоо хоног) Швейцарийн Женев хотноо хуралддаг.

Дэлхий дахинаа зэвсэгт мөргөлдөөн, тогтворгүй байдал газар авч, байгалийн гамшигт үзэгдэл гарах тохиолдол мэдэгдэхүйц нэмэгдэж, орлогын ялгаа, ядуурал дорвитой буурахгүй байгаа зэргээс үүдэн олон сая хүн эрүүл мэнд, амь насаараа хохирох, тахир дутуу болох, эх нутгаасаа дүрвэх, эрх ашгаа хамгаалах, хамгаалуулах боломжгүй нөхцөлд байгаа нь хүний эрхийг эрхэмлэх, хамгаалах үйл хэргийг хэзээ хэзээнээсээ илүү чухалчлах, үүнтэй холбогдон ХЭЗ-ийн ач холбогдол улам бүр өсөн нэмэгдэж байгаа юм.

Монгол Улс хөгжлийнхөө бодлогын төвд хүний эрхийг чухалчилдаг бөгөөд хуулийн засаглал, хүний эрх мөн ардчилал харилцан уялдаатай бэхжиж, хөгжих учиртай гэж үздэг. Ийм ч учраас Монгол Улсын үндсэн хууль болон бусад хууль тогтоомж Монгол Улсад хүний амьд явах эрх, эрх чөлөө, аюулгүй байдал, боловсрол, соёл, эрүүл мэнд, хувийн нууцтай байх мөн шашин шүтэх, үг хэлэх, эвлэлдэн нэгдэх, шилжин суурьших зэрэг эрхийг хамгаалсан байдаг.

Монгол Улс хүний эрхийг хамгаалахад чиглэсэн олон улсын 30 гаруй гэрээ конвенц, Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 20 конвенцид нэгдсэнээс гадна олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн тухай Женевийн 4 конвенцийн тал болсон.

Хүний эрхийг дээдлэх хамгаалах нь хүн төрөлхтөний үнэт зүйл бөгөөд тогтвортой байдал, хөгжил цэцэглэлийн бат бэх үндэс суурь учраас хүний эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжих үйл хэргийг дэлгэрүүлэх нь улс орон бүр, иргэн бүрийн эрхэм үүрэг, хариуцлага юм. Энэ нь үүднээс Монгол Улс олон улсын хамтын нийгэмлэгийн гишүүний хувьд бүс нутаг, олон улсын хэмжээнд хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, хөхиүлэн дэмжихэд хувь нэмрээ оруулах эрмэлзлээр,

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.1.1.2<sup>1</sup> дугаар зүйл, Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлалын 10<sup>2</sup>, 13<sup>3</sup> дугаар зүйл, мөн УИХ-ын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2011 оны №05 тогтоолын 9<sup>4</sup> дүгээр зүйлд заасан зорилт, чиглэлийг тус тус үндэс болгож Хүний эрхийн зөвлөлийн 2016-2018 оны гишүүний сонгуульд нэрээ дэвшүүлж буйгаа 2012 оны 1 дүгээр сарын 9-нд албан ёсоор мэдэгдсэн.

Хүний эрхийн асуудлын агуулга, ач холбогдлоос хамаарч Хүний эрхийн зөвлөлийн сонгууль нэн өрсөлдөөнтэй болдог бөгөөд Монгол Улс бодлого байр сууриа сурталчлах, улс орнуудын дэмжлэгийг авах чиглэлээр 2012-2015 он хүртэл идэвхтэй, шургуу ажилласны дүнд 2015 оны 10 дугаар сарын 28-ний өдөр Нью-Йорк хотноо НҮБ-ын Ерөнхий Ассамблейн чуулганы үеэр болсон НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн сонгуульд манай улс НҮБ-ын гишүүн 172 орны саналыг авч, Хүний эрхийн зөвлөлийн гишүүнээр анх удаа сонгогдсон. Хүний эрхийн зөвлөл дэх Ази, Номхон далайн бүлэгт ногдож буй 5 суудлын төлөө нийт 7 орон өрсөлдсөн бөгөөд Монгол Улс авсан саналынхаа тоогоор бүлгийнхээ хэмжээнд тэргүүлсэн.

Монгол Улс ийнхүү бүлгээсээ хамгийн олон саналаар сонгогдсон нь манай улсын олон улсын нэр хүндийн бодит илэрхийлэл болсон гэж үзнэ. Монгол Улс Хүний эрхийн зөвлөлийн гишүүнээр 2016-2018 онд ажиллах бөгөөд чингэснээр хүний эрхийг хамгаалах чиглэлээр олон улсын хамтын нийгэмлэгийн үйл хэрэгт хувь нэмрээ оруулах, олон улсын хэмжээнд шийдвэр гаргах түвшинд ажиллах боломжтой болсон.

Манай улс ХЭЗ-ийн гишүүнээр ажиллахдаа дараах чиглэлд тэргүүлэх ач холбогдол өгч байгаа болно. Үүнд:

- Жендэрийн тэгш байдлыг хангах;
- Хүүхэд, эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах;
- Хүний наймаатай тэмцэх;
- Арьс өнгө, хүйсээр үл ялгаварлах үзэл санааг дэмжих;
- Цаазаар авах ялыг халах;
- Итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг хөхиүлэн дэмжих;
- Эвлэлдэн нэгдэх эрх чөлөөг хөхиүлэн дэмжих зэрэг чиглэл багтана.

<sup>1</sup> “3.1.1.2. Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг хангах үндсэн арга нь улс төр, дипломатын үйл ажиллагаа байна. Энэ хүрээнд олон тулгуурт гадаад бодлогын зарчмыг эрхэмлэж, дэлхийн улс орнууд, олон улсын байгууллагуудтай идэвхтэй харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлнэ.”

<sup>2</sup> “10. Монгол Улсын улс төрийн гадаад харилцааны бодлогын зорилго нь ... олон улсын байгууллага дахь үйл ажиллагаагаа идэвхжүүлэх, дэлхий нийтийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд хувь нэмрээ оруулахад оршино.”

<sup>3</sup> “Монгол Улс дэлхийн хамтын нийгэмлэгийн гишүүний хувьд бүс нутгийн болон дэлхийн чанартай тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн бүх нийтийн үйл хэрэгт хувь нэмэр оруулахыг чармайна. Тухайлбал: - ардчиллыг бэхжүүлэх, хүний эрх, эрх чөлөөг хангахад чиглэсэн үйл ажиллагааг дэмжиж, идэвхтэй оролцох; ...”.

<sup>4</sup> “Олон улсын хамтын нийгэмлэг, НҮБ болон олон улсын бусад байгууллагын үйл ажиллагаан дахь Монгол Улсын бодит оролцоог тодотгох, цаашдын зорилтын талаарх дунд болон урт хугацааны стратегийн чиглэлийг тодорхойлох. Чингэхдээ НҮБ-ын Аюулгүйн Зөвлөл, Хүний эрхийн зөвлөлийн гишүүнээр ажиллах, боловсон хүчний чадавхийг бэхжүүлэх, шаардагдах хөрөнгө, санхүүгийн асуудлыг системтэйгээр шийдвэрлүүлэх чиглэлээр ажиллах”.